

Сурган хүмүүжүүлэгч Б.Одсүрэнгийн хөөмий заах арга барилын онцлог

Мөнхжаргалын Амаржаргал^{1*}
Цэрэнбалжирын Цэвэгсүрэн²
Дамдинсүрэнгийн Даваасүрэн³

¹ Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс

² Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

³ Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

ORCID: <https://orcid.org/0009-0009-4457-2717>

ORCID: <https://orcid.org/0009-0008-7598-8769>

ORCID: <https://orcid.org/0009-0008-7598-8769>

*Холбоо барих зохиогч: amaraamaa88@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүллтийн зорилго монгол хөөмийн танхимын сургалтын үндэслэгч, багш Б.Одсүрэнгийн сурган хүмүүжүүлэх арга ухааныг тодруулах замаар түүний заах арга, түүнд баримтлах зарчмуудыг авч үзэхэд чиглэгдэнэ. Үүний тул Б.Одсүрэнгийн хөөмийд суралцсан болон бусдад зааж сургасан туршлагыг онцлохыг зорив. Хэдийгээр дээд боловсролтой хөөмийч бэлтгэн төгсгөхөд сургалтын хөтөлбөрийн дагуу үндсэн чиглэлийг баримталж байгаа ч үндэсний язгуур урлагийг бусдад өвлүүлж байгаа талаараа багшийн заах арга барилд “шавь сургалт”-ын уламжлалт хэлбэр илүүтэй зонхилж байгааг тус өгүүллээр дамжуулан мэдээлэв.

Угтаа багшийн заах арга бол хөөмийн сургалт дахь “дэг сургууль”-ийн нэгэн бүрдэл болох юм. Монгол хөөмийн урлагт өөрийн гэсэн бүрдэл хэсгүүдтэй орчин цагийн дэг сургууль бүрэлдэн тогтоход онцгой хувь нэмэр оруулсан, амьдралынхаа 30 гаруй жилийг энэ салбарт зориулж, арвин туршлага хуримтлуулсан хүн бол яахын аргагүй хөөмийн урлагийн нэрт сурган хүмүүжүүлэгч, ерөөлч магтаалч, туульч Баатарын Одсүрэн юм. Түүний сурган хүмүүжүүлэх үзэл баримтлал, заах арга барилд туулж өнгөрүүлсэн амьдралын туршлага нь хэрхэн шингэсэн, цаашлаад хойч үеийн шавь нарынх нь заах арга барилд хэрхэн жишиг болж, мөрдөгдөж байгааг хичээл сургалтын үйл явц болон аман сурвалж, ярилцлагаас тодруулж, Б.Одсүрэнгийн гэх заах арга барилын хэв загвар тогтсон байгааг энэ өгүүллээр авч үзэв. Судалгаанд холбогдох өгөгдөл, мэдээллийг Монгол Улсын Соёл урлагийн их сургуулийн “Үндэсний язгуур урлаг” хөтөлбөрийн хөөмийлөх ур чадварын хичээлийн явцад зохион байгуулалтгүй ажиглалт хийж, сурган хүмүүжүүлэгч Б.Одсүрэн болон түүний шавь нартай ярилцах замаар цуглуулав. Тус судалгааг агуулгын шинжилгээний аргад тулгуурлан чанарын аргаар хийсэн болно.

Түлхүүр үгс: шавь сургалт, танхимын сургалт, дэг сургууль, хөөмийлөх ур чадвар

Characteristics of educator B.Odsuren's teaching methods

Amarjargal Munkhjargal^{1,*}

Tsevegsuren Tserenbaljir²

Davaasuren Damdinsuren³

¹ The Research Institute of Culture and Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

² School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

³ School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0009-4457-2717>

ORCID: <https://orcid.org/0009-0008-7598-8769>

ORCID: <https://orcid.org/0009-0008-7598-8769>

* Corresponding author: amaraamaa88@gmail.com

Abstract: This article aims to elucidate the fundamentals of B.Odsuren's teaching methodology, the pioneer of classroom training in Mongolian khuumii. It delves into the distinctive features of his teaching approach and the guiding principles it entails. To achieve this objective, an emphasis is placed on tracing B. Odsuren's journey in learning khuumii and his subsequent experience in imparting this skill to others.

The article highlights that while the structured training plans and curricula of formal khuumii education adhere to a standardized framework, the traditional approach of "Apprenticeship" remains prevalent in the teaching methodology of experienced practitioners. This method emphasizes the transmission of the traditional folk art from teacher to student, ensuring the preservation and continuation of cultural heritage.

In fact, the teacher's teaching method is a part of the "regulated school" in music education. Baatarin Odsuren, a well-known teacher of khuumii art, reciter and storyteller, who has made a special contribution to the formation of a training system with its own components in modern khuumii art, and who has accumulated rich experience for more than 30 years of his life in this field, is undoubtedly. This article examines how a special teaching pattern, named after the teacher Odsuren been formed, how his life experience was incorporated into his pedagogical concepts and teaching methods, and how he became a standard in the teaching methods of his future students, was revealed through the teaching process, oral sources, and interviews. The data and information relevant to the study were collected through unstructured observation and discussion with the educator B.Odsuren and his students during the course of the "Traditional folk art" program of the Mongolian National University of Arts and Culture. The research was conducted using a qualitative method based on the content analysis method.

Keywords: *student based training, regulated school, throat singing skill*

Оршил

Аливаа хөгжмийн уламжлалын хувьслын асуудалд түүний өвлүүлэлт, сургалтын хөгжлийн байдлыг судлан тодруулах нь зайлшгүй тул монгол хөөмийн уламжлалт сургалтын хөгжлийн асуудлыг түүний бүрдлийн нэгэн хэсэг болох багшийн заах арга барилтай нь холбон авч үзсэн болно. 1990-ээд оноос өнөөг хүртэл 30 гаруй жилийн түүхийг бүтээсэн хөөмийн танхимын сургалтын хөгжилд багшийн заах арга барил, түүний үзэл баримтлал, сургалтын орчны нөлөөлөл, суралцагчийн бүтээлч байдал гээд олон хүчин зүйлс хамаарах бөгөөд эдгээрийг цогцоор нь судлан тодруулах зайлшгүй шаардлагатайн дээр эл судалгаа нь хөөмийн уламжлалт урлагийн дэг сургуулийн асуудлыг хөндсөн судалгаанд хувь нэмэр болох ач холбогдолтой юм.

Дэлхий нийтэд ХХ зууны сүүлчээс урлагийн салбарын багшийн үр нөлөө, заах аргын загварын талаар Gholson (1998) нарын эрдэмтэд сонирхон судалж эхэлсэн бол америкийн боловсролын онолч, профессор David A.Kolb (1981) туршлагад суурилсан сургалтын системийг үндэслэж, загвар боловсруулсан байдаг. Харин 2000-аад оноос хойш нийгэм-соёл, нийгмийн практик, багш-суралцагчийн харилцан үйлчлэл талаас судлах болсныг Финландын их сургуулийн профессор, доктор (Ph.D) Нуру-Beihammer (2010) тоймлон тэмдэглэжээ.

Тэгвэл манай улсад хөөмийн уламжлалт урлагийн багшлах арга, дэг сургуулийн тухайд дагнан судалсан судалгааны үр дүн одоогоор хараахан гарч ирээгүй байна. Харин францын судлаач Жаонни Кюртэ (2018) монгол хөөмийн өвлүүлэлт талаас нь, ӨМӨЗО-ны судлаач О.Хийморьт (2024) хөөмийлөх ур чадварыг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, туршин судалсан байдаг.

Энэхүү судалгааны зорилго нь монгол хөөмийн танхимын сургалтын үндэслэгч, багш Б.Одсүрэнгийн сурган хүмүүжүүлэх арга ухааныг тодруулах замаар түүний заах арга, түүнд баримтлах зарчмуудыг авч үзэхэд чиглэгдэнэ. Үүний тул Б.Одсүрэнгийн хөөмийд суралцсан түүх болон бусдад зааж сургасан туршлагыг тодруулахыг зорив.

Судалгааны арга зүй

Тус судалгааг агуулгын шинжилгээний аргад тулгуурлан чанарын аргаар хийсэн. Бид судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийхдээ чанарын агуулгын шинжилгээг уламжлалт аргаар ашиглах хэлбэрээр багшийн туршлагаас шууд цуглуулсан. Мэдээллийн үнэн зөв байдлыг хангахын тулд шавь нарын үнэлгээ, тэдний ярилцлага, хамт ажиллагсдын тайлбар зэрэгт тулгуурласан ба хээрийн дадлагын хичээлд оролцох байдлаар мэдээллийн найдвартай байдлыг нэмэгдүүлэхийг хичээсэн.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн: Тус судалгааны эх хэрэглэгдэхүүнд хөөмийн багш Б.Одсүрэнтэй хийсэн цуврал ярилцлагууд, түүний заах аргыг уламжлан түгээж буй шавь нарын ярилцлага, Соёл урлагийн их сургуулийн “Дамжуулах үг” цуврал төслийн хүрээнд бүтээгдсэн Б.Одсүрэнгийн сурган хүмүүжүүлэх арга туршлагыг үзүүлсэн “Хүн-хөгжим” сургалтын баримтат кино, “Хөөмийлөх ур

чадвар” хичээлийн явцын ажиглалтын дуу, дүрсний бичлэгүүдийг тус тус ашиглав.

Судалгааны таамаглал: “Багш Б.Одсүрэнгийн ажил амьдралын практик туршлага хийгээд олж авсан мэдлэгийн нэгдэл нь хөөмийн танхимын сургалтаар дамжин туршигдаж, орчин цагийн сургалтын дэгийг бүрдүүлсэн” байж болзошгүй хэмээн таамаглав.

Судалгааны үр дүн

Б.Одсүрэнгийн хөөмийд суралцсан туршлага

Нэг нь нөгөөг даган дуурайх оролдлогоор хөөмийд суралцах хандлага 1930-аад оны сүүл үеэс эхэлсэн байх талтай. Учир нь судлаач Ж.Энэбиш (2007)-ийн хөөмийн тухай аман сурвалжид 1938 онд хөөмий гэх хачин сонин дуу авиа дуугаргадаг нэг айлын 2 хүү байсан тухай мэдээлсэн байдаг. Ингэж бие биеэ даган дуурайх оролдлогоор хөөмийн дөрийг олж, дуугарч сурсан хүмүүсийн тоо цөөн цөөнөөр нэмэгдсээр 1980-аад оны дунд үед эрчимтэй хөгжсөн гэж хэлж болмоор. Даган дуурайх оролдлого аажимдаа “гэр сургалт”, “шавь сургалт”-ын хэлбэрт шилжин хувьсаж, өнөөгийн судлаачдын хэлэлцэх “хөөмий заах уламжлал”-ыг бий болгожээ.

Сурган хүмүүжүүлэгч Б.Одсүрэн анх 6, 7-н настайгаасаа нутгийн ах нарын хачин сонин дуугарахыг сонсож, тэднийг даган дуурайж эхэлсэн байдаг. Жамбал, Мягмар, Түвд гэх нутгийн ах нар нь өөрөөс нь арав гаруй насаар ах гэх бөгөөд тэд анх хаанаас хөөмий сурсан талаарх мэдээлэл одоогоор тодорхой бус. Өөрсдийг нь дуурайж, сурах гэж оролдлого хийгээд байгаа балчир хүүхдийг анзаарсан тэд тэсвэр тэвчээрийг нь шалгах, зөв бурууг нь хэлж өгөх зэргээр санамсаргүй байдлаар Б.Одсүрэнд хөөмийлөх анхны дөрийг суулгасан гэж хэлж болно.

Завхан аймгийн Алдархаан сумын Өгөөмөр багийн нутаг дахь Борхын голын эрэг, ойр орчмын говь хангай хосолсон өвөрмөц байгалийн тогтоц нь тэдний хөөмийн сургалтын орчин байсныг ч мөн аман түүх өгүүлнэ. Харин хатуу ширүүн боловч зөвийг чиглүүлсэн нутгийн ах нарын монгол ухаан бол тэдний заах арга барилын хэлбэр байсныг судалгааны явц гэрчилнэ. Ийнхүү одоогоос 70-аад жилийн өмнөх үйл явдлыг аман сурвалжаар мөшгөн үзэхэд дараах байдлаар өгүүлснийг энд сийрүүлбэ.

...миний аав сайхан унзад хоолойтой лам хүн байсан, манай аавыг ламдаад¹ байна гээд хонь ямаа хариулуулж хол нутаглуулдаг байлаа... Би өдөртөө Борхын голын эргээр л “тэмээ” Лувсанцэрэн, Цэрэндорж, Лхамсүрэн гээд үе тэнгийнхнээс гадна Жамбал, Мягмар, Түвд гэдэг нутгийн ах нарыг бараадан өнжинө. Нутгийн ах нар сайвар морин дээр энгэр задгай исгэрнэ, усанд шумбаж, сэлнэ, хачин сонин авиаг хоолойгоороо гаргана... Тэдний энэ байдлыг ихэд сонирхож дуурайж оролдоно... Ах нар намайг хэдийнээ анзаарчхаад усанд толгойг минь дүрж “одоо уу уу уу гэж дуугар” хэмээн тэвчээр шалгана. Тухайн үед ус залгиж хахаж цацна..., дараагийн удаад арай дээрдэнэ... ...зүлгэн дээр намайг дээш харуулан хэвтүүлээд гэдэс рүү дарж үзнэ, сууж ч үзнэ, тэгээд “одоо дуугар” гэнэ, бодоход тэр нь амьсгааны байдлыг шалгаж байсан болуу... Мөн намайг хэлээ гарга, хэлээ доор тавиад хонхойлго гэнэ... Мягмар ах надад морио

¹ Ламдах: Бусдын тусын тулд ном уншиж, засал хийх (Б.Одсүрэнгийн тайлбараар)

өгч уулын өөд рүү яваад хонь эргүүлэнгээ дуугараад ир гэнэ... “Морины чих хөдөлж байвал чамайг сонсож байна аа л гэсэн үг шүү” гэж хэлээд явуулдаг байлаа... Уулын өөдөө салхитай салхигүй янз янз л байна. Хэлснийх нь дагуу дуугараад л байна... Мөн тэмээн дээр “өү өү өү” гээд дуугар гэнэ. Энэ мэтчилэн өдөр бүр голын эрэг очих далимаар нутгийн ах нарын чадварт суралцах гэж хичээнгүйлнэ. Тэднээр шоглуулж, дэглүүлж байгаа шиг санагдавч хүсэл сонирхолдоо хөтлөгдөн дараагийн өдөр дахин шантралгүй очсоор л... (Одсүрэн 2024а, 01:54:32).

Ингэж хөөмийлөх аргын анхны мэдэгдэхүүнийг олж авсан тэрээр өсөж том болохдоо он цаг улирах тусам сурч мэдсэн зүйлсээ ажиглалт туршилтаар улам хөгжүүлж иржээ. Тухайлбал:

- хавар, зуны цагт ижил сүргээсээ хоцорсон хурга ишгийг өргөж уулын өөд ижилд нь нийлүүлэхдээ,
- өвлийн цагт голын мөсөн дээр цана, тэшүүрээр гулгахдаа,
- хаврын цагт салхи сөрөн алхахдаа мөн л хөөмийлсөөр байсан нь түүний санамсаргүй үйлдлийн идэвхтэй ажиглалт болохын зэрэгцээ арвин туршлага болж хуримтлагдсан байна.

Өнөөдөр хөөмийн урлагт нэр алдраа цуурайтуулсан хөөмийч Д.Сундуй, Р.Даваажав, У.Тойвгоо, Т.Ганболд, Д.Цэрэндаваа нарын алдарт хөөмийчдийн хөөмийлөх арга барил нь харилцан адилгүй, өөрсдийн гэсэн онцлогтой гэдгийг дурдахгүй өнгөрөхийн аргагүй юм. 1980-ээд оноос хойш тэдний хөөмийлөх ур ухаан, арга барилаас суралцаж, тэдэнд шавь орох хүсэл тэмүүлэлтэй хүүхэд залуусын тоо олширсон байдаг. Түүнийхээ хэрээр ч эдүгээ дээрх нэрт хөөмийчдийн үргэлжлэл болох олон арван хөөмийчид дараа дараагийн шавь нараа бэлтгэсээр байгаа нь сайшаалтай юм. Ингэхдээ ихэвчлэн багшаасаа суралцсан туршлагатаа тулгуурлан шавь сургалтын аргаар залуу хойч үеийнхнийг дагалдуулан сургасаар байгааг аман сурвалжууд мэдээлж байна.

Б.Одсүрэнгийн бусдад хөөмий заасан туршлага

Цэргийн албаны карантин, тэр хугацаанд зохион байгуулагдсан урлагийн үзлэг бол Б.Одсүрэнгийн дуулдаг, хөөмийлдөг авьяасаа бусдад таниулах боломж байсан. Учир нь “Гоож нанаа” дууг хөөмийлж, “Цэргийн бодол” дууг дуулж үзүүлсэн тэр цаг мөч түүнийг хөгжмийн салааны цэрэг болоход чиглүүлж, улмаар армийн хурандаа Жамбалсүрэнгийн Дэндэв гэдэг багшаар ноот заалгаж, хөгжмийн онолын мэдэгдэхүүнтэй болж, тромбон, балторн хөгжимд суралцсан байдаг. Тэндээсээ армийн тусгай тагнуулын салаа, жолооны 107-р цэргийн анги гээд цэргийн салбартаа дамжин ажилласан.

1976 оноос жолооны багшаар ажиллах хугацаа түүнийг бусдад хөөмий заах эхлэлийг тавьсан гэж хэлж болно. Учир нь тэнд ажиллах хугацаандаа буюу 1981 онд Ардын хувьсгалын 60-н жилийн ойн хүрээнд улсын хэмжээнд урлагийн үзлэг, шалгаруулалт зарлагдаж, түүнд жолооны багш н.Ганболд, н.Батмөнх нартай хамтарч язгуур урлагийн үзүүлбэрээр оролцох үүрэг даалгавар авч байжээ. Улмаар тэд “Алтайн магтаал”-аар оролцохоор шийдэж, н.Батмөнх нь цээл хоолойгоор дуулахыг хариуцаж, харин Б.Одсүрэн н.Ганболд нар хөөмийн шахаагаар хамт дуугарахын

тулд 7 хоногийн турш нэг нь нөгөөгөө дагуулан сургах байдлаар бэлтгэсэн байдаг.

Дээрх үзлэг шалгаруулалтын дараа тэд ажлаа эрхлэх зууртаа Сүхбаатарын районы “Ардын уянга” хамтлагт орж, соёл олон түмний ажилд оролцох болсон. Тухайн хамтлагийн бүрэлдэхүүнд хөөмийч Г.Чимэддоржийн ёочинчин байсан, Улсын багшийн сургуулийн н.Содномдулам багш байсан ба хамтлагийн дасгал сургуулилтын үед “Г.Чимэддоржийн хөөмийлөх арга барил, хөөмийн амьсгаа гэж юу болох” тухайд олон сонирхолтой аман мэдээг хуучилдаг байсан нь Б.Одсүрэнд хөөмийн амьсгааны нарийн учрыг мэдэж авахад чухал дэм болсон аж.

Үүний дараа 1986 онд Ж.Бадраагийн дэмжлэгээр “Үлгэрийн танхим”-д очиж, Жамцын Чойён багшид шавь орсноор ерөөл, магтаал, тууль хайлах арга ухаанд суралцсан. Ийнхүү “Үлгэрийн танхим”-д Ж.Чойён багшийгаа залгамжлан ажиллах хугацаандаа “Түмэн эх” чуулгат хэд хэдэн хөөмийчийг бэлтгэж, улмаар ӨМӨЗО-ны Урлаг жүжгийн хүрээлэн, АНУ-ын Индиана их сургууль, ОХУ-ын Буриад улсын Байкал чуулга зэрэгт хоёр улсын гэрээ хэлэлцээр болон дээд түвшний удирдах газрынх үүрэг даалгавраар удаа дараа зочлон очиж танхимын сургалтаар нэгэн зэрэг олон хүнд монгол хөөмийн онцлогийг таниулах, хөөмийлөх аргын анхны ойлголтыг өгөх, сургах зэргээр заах аргын туршлага хуримтлуулсан байдаг. Эдгээр он жилүүд өнөөдрийн хөөмийн танхимын сургалтыг хөгжүүлэхэд чухал туршлага болсон талаар ийн өгүүлдэг:

...1989 онд “Түмэн эх” чуулга байгуулагдаж, чуулгын уран бүтээлчдийг хөөмийд сургах шаардлага гарч, эхлээд Хөгжим бүжгийн дунд сургуулиас орж ирсэн бишгүүр хөгжимчин Гантулгад, араас нь морин хуурч н.Түвшинбаяр, дуучин н.Батжаргал, бүжигчин н.Лувсандагва, эвэр бүрээчин н.Өлзийсайхан гээд хөөмийлөх дөргүй, цагаанаараа байсан эдгээр нөхдөд хөөмий зааж эхэлсэн... Тэр үед хөөмийн шахааг дуугарахад хүнд жинтэй юм өргүүлж дуугаргах нь дуугаралтын хүч хийгээд амьсгааг зөв авахад нөлөөлж байгааг ухаарсан. Тухайн орчинд өргөх хүнд чулуу гэж байсангүй, боломжтой нөхцөлөө ашиглан төгөлдөр хуур хөгжмийн булангаас өргүүлж дуугаргадаг байлаа. Мөн өмнө нь Сүхбаатарын районы “Ардын уянга” хамтлагт байхдаа Ганболд дээр туршиж үзэж байсан аргаараа амьсгааны байдлыг шалгаж, газар эсвэл сандал дээр хэвтүүлж, хөл, толгойг газраас хөндийрүүлэх байдлаар амьсгааны түгжилтийг хэвлийд төвлөрүүлэх аргыг “Түмэн эх”-ийнхэнд туршиж хэрэгжүүлсэн. Ер нь нэг танхимд олон хүнд хөөмийлөх арга барилыг чиглүүлэх явцад суралцагчид харилцан бие биенээсээ суралцах, өөрийнхөө ахиц дэвшил, болж байгаа, болохгүй байгаагаа бусадтай харьцуулж сонсох байдлаар урагшлан сайжирдгийг тэр үеэс анзаарч мэдсэн... (Одсүрэн 2024б, 01:14:32).

Харин хөөмийн урлагийг бусдад зааж чиглүүлэх дасгал сургуулилтад ардын аман зохиолоос ашиглах, түргэн хэллэг, жороо үг хэлүүлэх нь хэл уруулын булчинг суллаж өгөхийн зэрэгцээ үг хэлийг хурц тод хэллэгтэй болох, ярих чадварын тал дээр чухал нөлөөтэй байсныг гадаадын хүмүүст зааж сургах явцаас олж мэдсэн талаараа дараах байдлаар өгүүлдэг.

... ӨМӨЗО, АНУ, ОХУ гээд хэд хэдэн газарт ихэвчлэн 2 сарын хугацаанд хөөмий зааж сургах үүрэг даалгавар аваад явдаг байсан. Тухайн улс

үндэстний хэл ярианы онцлогт нь тохирсон, өөрснийх нь аман ярианд түгээмэл хэрэглэгддэг, тэдний сайн мэдэх үг хэллэгийг хөөмийн шахаагаар хэлүүлэх байдлаар хичээлийн явцыг сонирхолтой болгох гэж үзнэ. Тухайлбал, америк хүмүүсээр “hi, all” гэх зэрэг үгсийг хэлүүлэхэд монгол хэлний “я”, “л” төст авиа сонсогдох тул түүгээр дамжуулан хэлний үзүүр болон дунд хэсгийг тагнай тийш түлхэн шахахад хөөмийн исгэрээ сонсогдож эхэлдэг талаар ойлгуулахыг хичээдэг байлаа. Хэл ойлгохгүй гадаад хүнд хичээл заана гэдэг амаргүй байсан., өвөр монгол, буриадууд бас ч учиртай, үг яриагаа ойлголцоно. Гэсэн ч тэд миний хэлүүлэх үгийг буруу хазгай хэлэх үе зөндөө гарч ирнэ. Исгэрээ хөөмийн үндсэн арга барилд хэлний үзүүр тагнай руу чиглэж байрладгийг ойлгуулах санаагаар тэд нараар “л” гийгүүлэгч оролцсон, “л” гийгүүлэгчээр төгссөн үг хэлүүлэхийг ихэд хичээнэ, гэтэл өвөр монголчууд “гурил”-ыг “гулир” гэж хэлэх жишигтэй. Энэ мэт байдлаас үүдээд монгол ардын аман зохиол, тэр дундаа цээжлэхэд хялбар, богинохон жороо үг, түргэн хэллэгийг дасгал сургуулилтад ашиглах нь өгөөжтэй болохыг анзаарсан. Түүнээс хойш хичээл заах аргад “л, р” гийгүүлэгч авиа түлхүү оролцсон “Хүрэл илүүр, болор соруул”, “Ээрүүл, хайруул, хусуур гурав”, “Элээ, хэрээ, галуу гурав”, “Билүү чулуу, илүү билүү” гэх зэргийг түргэн хэллэгүүдийг түгээмэл ашиглах болсон... (Одсүрэн 2024в, 36:24).

Б.Одсүрэн нь 1998, 1999 оны үед урлагийн төрөлжсөн сургалттай “Монгол гайхамшиг” сургуульд Э.Бат-Оюун, н.Мөнгөншагай, Н.Наранбадрах, С.Загд-Очир, Л.Хэрлэн тэргүүтэй олон шавь нарыг бэлтгэх зууртаа өөрөө давхар суралцаж байсан тухайгаа мөн аман сурвалждаа өгүүлдэг. Тэрээр 2001 оноос МУИС-ийн “Ардын урлаг судлал”-ын тэнхимд багшлах боломж гарахад, “Монгол гайхамшиг” сургуульд суралцаж байсан шавь нарын зарим нь багшийгаа даган их сургуулийн элсэлтийн шалгалт өгч оюутан болж байжээ. Ийнхүү тус тэнхимийн багш Р.Оюунбат, эрхлэгч Ж.Төмөрбаатар нарын дэмжлэг, хүчин чармайлтаар ардын урлаг судлаач болон бэлтгэгдэх хөтөлбөрийн “Сурах арга”-ын хичээлд хөөмийн хичээл нэмэгдсэн түүхтэй. Ардын урлагийн аливаа төрлийг судлагчид тухайн чиглэлдээ бага ч болов мэргэшсэн байх ёстойг тус тэнхимийг үүсгэн байгуулагчдын нэг, хөгжим судлаач Ж.Бадраа хэлж ярьдаг байсныг тэнхимийн ахмад багш нар өгүүлдэг.

Б.Одсүрэнгийн өдөр бүр хөөмийн хичээл ордог байсан хэлбэр их сургуулийн орчинд өөрчлөгдөж, тусгай хөтөлбөрөөр ерөнхий эрдэм, мэргэших хичээлүүдийг тодорхой цагийн дагуу суралцаж буй оюутнуудад долоо хоногт зөвхөн нэг удаа 1-2 цагийн хичээл ордог болсон. Ингэхдээ судлаач болох бүх суралцагчдад орох бус ихэвчлэн нэг ангиас 1-3 оюутан хөөмийн хичээлийг сонгоно. Тэнд хүн нэг бүртэй тулж хичээллэх цаг, нөөц боломж хомс тул анги, курсээр нь зааглахгүй тус хичээлийг сонгосон бүх л оюутнууд нийтээрээ нэг танхимд багшийн заавраар нэг нэгнээ дуурайн суралцдаг байжээ. Энэ мэт байдлаас үүдэж, багш Б.Одсүрэн хөөмийн хичээлийн үр дүнг сайжруулах үүднээс байнга танхимд хичээллэх бус зарим нэг өдрийн хичээлийг задгай талбайд буюу гадны орчинд оруулж байхаар шийдэж, өндөрлөг газарт салхи сөрүүлэн хөөмийлүүлж үзэх оролдлогоо туршиж

үзсэн тухайгаа дараах байдлаар өгүүлдэг.

...“Монгол гайхамшиг” сургуулийн байдал жаахан тиймхэн болсонтой зэрэгцээд МУИС-ийн ардын урлаг судлалын тэнхимийн багш Равжаагийн Оюунбатын санал, санаачилгаар тус тэнхимийн оюутнуудад “хөөмий сурах арга”-ын хичээл орох болсон. Тэнд их сургуулийн дүрэм журам, хөтөлбөрийг дагах тул өдөр бүр хөөмийн хичээл орох боломжгүй байлаа. Хөөмийн талаар “а” үсэг ч үгүй нөхдүүд бие биеэ даган сонирхож, анги бүрээс ганц хоёроороо орж ирнэ. Тэдэнд “Монгол гайхамшиг”-аас очсон н.Мөнгөншагай, С.Загд-Очир нар маань өөрсдийн мэддэг чаддагаа үзүүлж, надтай зэрэгцээд нөгөөдүүлийг бас зааж чиглүүлнэ. Өдөр бүр хамтдаа хичээллэхгүй тул тэдний ур чадварыг явал ахиулах талаар элдэв зүйлийн юм бодогдоно... Тухайн үед оролдлого сайтай хүүхдүүд хичээж өдөр бүр давтана, зарим нь нэг хичээл дээр аштайхан болж явчхаад дараа ирэхдээ өмнөхөөсөө өөр болоод ирэх жишээтэй. Ингээд танхимын хичээлийн хажуугаар хээрийн сургалт хийж турших санаа төрж, хүүхдүүдээ дагуулаад “Зайсан толгой”-руу гарч билээ. Тэнд хөшөөний урд тал руу одоогийнх шиг их барилга байшин байсангүй хээр хөдөө л байлаа. Хотгор гүдгэр харилцан адилгүй хэсэгт хүүхдүүдээ тарааж зогсоогоод салхи сөрж болон салхины уруу харуулан дуугаргаж үзнэ. Мөн тэдний дуугаралтын хүчний ялгаатай байдлыг сонсохоор алхмын хэмжээгээр хол ойр харилцан адилгүй зогсоож, хэн хэд алхмын цаанаас сонсогдож байгааг олж мэдэх гэх зэргээр жижиг жижиг туршилт судалгаа хийж, хүүхдүүдээ хөгжүүлэнгээ өөрөө ч суралцаар л байлаа... (Одсүрэн 2024б, 00:47:22).

Соёл урлагийн их сургуулийн хөгжмийн онолын тэнхимийн эрхлэгч хөгжим судлаач Г.Ганцэцэгийн санаачилгаар тус сургуульд “Монгол хөөмэй”-н мэргэжлийн анги нээгдэх болж, 2003 оноос бэлтгэх ажлууд хийгдэж багшаар Б.Одсүрэн уригдаж, сургалтын албаны дарга Д.Сүхтоого, сургуулийн захирал Д.Цэдэв нарын дэмжлэгээр тухайн онд цөөн тооны оюутанд туршилтын хичээл зааж эхэлжээ. Улмаар 2004 оноос БСШУЯ-аас батлагдсан D2012800 хөтөлбөрийн дагуу албан ёсны сургалтаа эхлүүлж, анхны төгсөлтөө 2009 онд хийж байсан түүхтэй. Энэхүү танхимын сургалтын он жилүүдэд Б.Одсүрэн нь өмнө олж мэдсэн мэдлэг, туршлагадаа үндэслэн жилээс жилд суралцагчийг хөгжүүлэхийн тухайд олон арван санал, санаачилгыг гаргаж, туршилт судалгаагаар зогсолтгүй үргэлжлүүлсээр байсан. Ийнхүү монгол хөөмийн танхимын сургалтад Б.Одсүрэнгийн мэдлэг, туршлагад суурилсан сургалтын дэг бүрэлдэн тогтсон байх магадлалтай байна.

Б.Одсүрэнгийн заах арга барилын онцлог

Б.Одсүрэнгийн бага насны дурсамж болон орчны нөлөөллөөс үүдсэн идэвхтэй туршилтын үр дүн зохих мэдлэгийг бүрдүүлж, орчин цагийн хөөмийн танхимын сургалтад туршигдсаар байна. Тэрээр туршлага хуримтлуулах явцдаа хөөмийн талаарх өөрийн гэсэн үзэл хандлагыг хичээл сургалтын явцад мөрдлөг болгож байгааг харж болно. Тухайлбал,

- Хөөмийлөх гэдэг бол эрүүнээс эгэм хүртэлх дөрвөн хуруу зайнд байрлах эрхтний идэвхтэй оролцоогоор хөгжмийн давхцал эгшиг үүсгэхийг

хэлнэ...

- Хөөмий бол хүнээр хөгжим бүтээж байгаа хэрэг буюу “хүн хөгжим”...
- Хөөмий нь хүн-байгаль-амьтантай харилцах үр дүнд тэдгээрийн шүтэлцээнээс үүсэж бий болсон урлаг... гэх мэт эдгээр болно.

Мөн бусдад хөөмий зааж эхлэхдээ суралцагч бүрийн зан байдал, бие, сэтгэхүйн онцлогийг нарийн шинжиж, амьдрал ахуйн нөхцөл, эрүүл мэндийн байдал зэргийг ажиглаж, суралцагч бүрд тохирсон арга барилаар хүн нэг бүртэй тулж ажилладаг. Тухайлбал, дуугаралтын хүч султай, өнгө эгшиг төдийлөн сайнгүй суралцагчийг алхам алхмаар сайжруулах байдлаар зөөлөн аргаар хөгжүүлэх, өнгө хүч сайтай дуугарч байгаа суралцагчийг хэт хүчилж чанга дуугаргахгүй, эвийг нь тааруулж чиглүүлэх гэх мэт. Сургалтын явцад суралцагчийн тэвчээр алдагдах, бие ядрах, хоолой хорсох гэх мэт олон асуудал, бэрхшээлүүд тулгарах ч тухайн нөхцөл байдалд тохируулан багш хичээл заах арга, хэлбэрээ өөрчилж, тоглоомын хэлбэрт шилжүүлэх байдлаар суралцагчийг идэвхжүүлэх, сурах хүсэл тэмүүллийг нь өдөөж, сэтгэл санаанд нь дэм өгөх аргуудыг хэрэглэдэг. Энэ мэт байдлаас үүдэж судлаачид багш хүн бол “...суралцагчийн мэдрэмжийг харгалзан үзэх, ямар аргаар сурган хүмүүжүүлэх вэ? гэсэн нарийн тактиктэй байх нь чухал...” (Van Manen 1991, 146) гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

“Хөөмийлөх ур чадвар” олгох анхны суурь хичээлд хөөмий төст авиаг мал, амьтны дууг дуурайлган дуугаргах (тэмээ буйлах, үхэр мөөрөх, хонь ямаа майлах, чоно, нохой, баавгайн архиралт гэх мэт) маягаар үүсгэх бөгөөд үргэлжлүүлэн хэл, уруулын булчин суллах, амьсгаа уртасгах дасгалуудыг хэрхэн хийлгэж буйг сонирхох үүднээс өдөр тутмын хичээлийн явцад зохион байгуулалтгүйгээр ажиглалт хийхэд дараах үйлдлүүдийг суралцагч оюутнаар тогтмол давтамжтай, тодорхой дараалалтай хийлгэж байгаа нь анзаарагдсан. Эдгээр нь:

- Мотоцикл, машины чимээг хэл доргиулан дуурайлгах;
- Хоёр завжинд шагай, лонхны бөглөөг хийж дуугаргах;
- 32 цагаан лонх, 64 хул тоолуулах;
- Орчин цагийн монгол хэлний “л”, “р” гийгүүлэгч түлхүү оролцсон түргэн хэллэг, жороо үг, холбоо үгсийг хэлүүлэх;
- Өөрийн дуугаралтыг нь алганы хонхорхойд ойлгон сонсгох;
- Хэвлий хэсэгт хуралдсан амьсгааг гараар болон өвдгөөр дарж шалгах;
- Хэвтээ байдалд хөл, толгойг газраас хөндийрүүлж дасгал сургуулилт хийлгэх (танхимын сургалтын үед сандал дээр хэвтэх, хээрийн дадлагын үед зүлгэн дээр хэвтэх байдлыг чухалчилна);
- Суралцагчийн биеийн жинд тохирохуйц хүндийн өргөлт хийлгэж дуугаргах (танхимын сургалтад элс, хээрийн сургалтад чулуу өргүүлэх)
- Хээрийн дадлагын үед урсгал усанд нүүрийг дүрүүлж үлээлгэх, голын хайрган дээр хөл нүцгэн алхуулж дуугаргах, салхи сөрүүлэн дуугаргах зэрэг юм.


Дээрх үйлдэл бүхэн тодорхой зорилгоор хийгддэг талаарх мэдээллийг хичээл заах багш нар өгүүлдэг. Тухайлбал, авсан амьсгааг зөв хуваарилах, уушгины багтаамжийг тэлж сайжруулах зорилгын хүрээнд 32 цагаан лонх тоолох, түргэн хэллэгийг нэг амьсгаанд олон хэлэх, хээрийн дадлагын үед урсгал усанд нүүрийг

дүрж удаан хугацаанд үлээлгэх гэх зэрэг дасгалууд чиглэгдэх бол хэл, уруул, завж гэх мэт өгүүлэх эрхтний булчин суллах зорилгод мотоцикл машины чимээг дуурайх, завжинд шагай болон шилний таг зэргийг хийж дуугаргах, мөн “л, р” гийгүүлэгч түлхүү оролцсон түргэн хэллэг хэлүүлэх зэрэг нь хамаарна. Харин суурь өнгийг ширгээж, исгэрээг тодруулах, өнгө тогтоох, хүч нэмүүлэх зорилгод хүнд юм өргөсөн байдлаар дуугарах, салхи сөрж дуугарах, амны хөндийгөөс гарч буй хөөмийн авиа эгшгийг алганы хонхорхойгоор дэмжиж сонсгох гэх зэрэг үйлдлүүд хамаардаг байна. Ийнхүү багш өөрийн заах аргын туршилт судалгааг ганцаарчилсан хичээлийн явц болон хээрийн дадлага, сургуулилтад хэрэгжүүлсэн үр дүнгээ жилээс жилд бататган сайжруулж, монгол хөөмий заах аргын онцлогийг баяжуулсаар байна. Түүний шавь нарт ч заах аргын эдгээр барилууд шингэн уламжлагдаж, улмаар хил дамнасан соёл болон тархан хөгжиж байна. Үүнийг танхимын сургалт дахь ганцаарчилсан сургалтын үр дүн буюу шавь сургалтын тогтолцооны уламжлал хэмээн хэлж болмоор байна.

Хэдийгээр багшийг дагалдан сурах буюу монголчуудын нэрлэж заншсанаар “шавь сургалт”-ын аргыг барууны зарим орнуудад “багш төвтэй” арга хэмээн шүүмжилдэг ч урлагийн төрлүүдээр дагнасан их дээд сургуульд, ялангуяа үндэсний язгуур урлагийн төрлүүдийг өвлүүлэх, уламжлуулах, тэдгээрийг танхимын сургалтад нэвтрүүлэхийн тухайд илүү зохимжтойг судалгааны үр дүн төдийгүй сургалтын үйл явц нотолсоор байна.

Ийнхүү хөөмийн танхимын сургалтад Б.Одсүрэнгийн туршлагад суурилсан заах арга барилын хэв загварыг америкийн боловсролын онолч Давид А.Колб (1981)-ын дэвшүүлсэн “Туршилтаар танин мэдэх онол”²-д суурилан танин мэдэх, ажиглан хөгжүүлэх, турших гэсэн үндсэн гурван үйлдлийн тогтолцооны хүрээнд мэдлэг, дадлага, чадварыг тойргийн хүрээнд хэрхэн бий болгож буйг харуулах оролдлогыг дараах байдлаар зураглаж болмоор байна (*Зураг 1*).

² А.Колб уг онолоо дөрвөн үе шатаар тайлбарладаг. Нэгдүгээрт, сургалтын явцын ажиглалтаар шууд ба тодорхой туршлага бий болгодог; Хоёрдугаарт, ажигласан зүйлсээ эргэцүүлж ямар мэдээлэл олж авсан түүнийгээ нэгтгэж онол болгон бүтээдэг; Гуравдугаарт, таамаглал дээрээ үндэслэн хийсвэр ойлголт бүрдүүлдэг; Дөрөвдүгээрт, олж авсан мэдлэгээ шинэ нөхцөл байдалд туршиж үздэг. Энэ үе шатын дараа сургалтын процесс эргээд эхний үе шатаас эхэлдэг тойрогт зарчимтай хэмээжээ.



Зураг 1. Б.Одсүрэнгийн хөөмий заах арга барилын “Турилагад суурилсан загвар”

Хэлэлцүүлэг

Хөөмийн танхимын сургалтын эхлэлийг судлаач А.Цэдэн-Иш (2009) “... анхлан тавигдсан хөрс суурь нь Монголын Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн “Үлгэрийн танхим”-тай салшгүй холбоотой... энэ алхмыг Баатарын Одсүрэн гэдэг хүн хийсэн гэдэгтэй хэн ч маргахгүй...” (Цэдэн-Иш 2009, 81) хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэгвэл бидний судалгааны явцад Б.Одсүрэнгийн хөөмий зааж эхэлсэн цаг үе “Үлгэрийн танхим”-аас өмнө 107-р жолооны цэргийн анги болон Сүхбаатарын районы “Ардын уянга” хамтлагтай салшгүй холбоотой болох нь ажиглагдав.

Харин ганцаарчилсан болон багшийг дагалдан сургах энэхүү сургалтын хэлбэрийг олон улсад Klaus Nielsen, Steinar Kvale (1997) нарын судлаачид “хаалганы цаадах нууц үйл ажиллагаа” мэтээр үзэж “багшийн эрх мэдэлд суурилсан загвар” хэмээн шүүмжилдэг бол судлаач Хири-Бэйхамер (2010) энэ хэлбэрээр сургах нь “хамгийн тохиромжтой сургалтын арга” гэсэн байдаг. Судлаачдын хэлснээр зарим талаар өрөөсгөл талтай ч гэлээ уламжлалт урлагийн сургалтын тухайд энэ арга нь оюутан бүрийн онцлогт тохирсон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хувь хүний шинж чанарыг төлөвшүүлэх давуу чанаруудтай байдаг нь судалгааны явцаас ажиглагдсан. Суралцагч бүр багшийн туршилагад дагалдан суралцахдаа өөрсдийн хэрэгцээний дагуу нийцүүлж мэдлэг олж авч, түүнийгээ харилцан адилгүй хэлбэрээр хөгжүүлдэг. Өнөөдөр манай улсад зөвхөн хөөмийлөх урлаг бус дуулах урлаг, хөгжимдөх урлаг, жүжиглэх урлаг гээд ихэвчлэн “performing art” буюу гүйцэтгэх урлагийн төрлүүдээр хичээллэж байгаа суралцагчид багшийг дагалдах

байдлаар, ганцаарчилсан сургалтын хэлбэрээр мэдлэг олж авч байна. Иймээс бидний судалгааны явцын ажиглалт хийгээд аман сурвалжийн мэдээ нь үндсэндээ судлаач Хири-Бэйхамерын саналтай нийлж байгаа юм.

Хөөмийн урлагийн хөгжил дэх сургалтын нөлөөний тухайд судлаач Жаонни Кюртэт (2018) “хөөмийн урлаг сургалтын хэлбэрээр дамжин тайзны урлаг болон хувьсаж мэргэжлийн хэмжээнд хөгжиж байгаа нь хөдөөгийн ардын авьяастны практик сургалтад нөлөөлж, улмаар тайзны уран сайхны шинжтэй жишиг дуурайл бий болоход хүргэж байна” гэсэн чухал санааг онцлон тэмдэглэсэн бол судлаач О.Хийморьт (2024) хөөмийн сургалт өнөөгийн байдлаар мэргэжлийн хөөмийч бэлтгэх 4 жилийн бакалаврын болон сонирхогчдод зориулсан богино хугацааны сургалт гэсэн хоёр чиглэлээр уламжлалт (гэрийн, шавь, хээрийн, ганцаарчилсан), орчин үеийн (танхимын, цахим, хэсэгчилсэн, нийтийн) гэсэн зохион байгуулалтын 8 хэлбэрээр хөгжиж байна хэмээн үзсэн байдаг. Судлаач О.Хийморьтын судалгааны дүгнэлт бүхий хөөмийн сургалтын чиглэл болон зохион байгуулалтын хэлбэрийн тухай асуудал бидний энэ удаагийн судалгааны зорилготой шууд хамааралтай бус ч шууд бусаар хамаарах тул цаашид нягтлууштай.

Дүгнэлт

Монгол хөөмийн сургалтын хөгжлийн асуудал нэгэн жарнаас бага хугацаанд хамаарах хэдий ч зах зээлийн эдийн засаг руу шилжих түүхэн цаг үетэй зэрэгцэн жилээс жилд хувьсан өөрчлөгдсөөр иржээ. Эдүгээ хөөмийн сургалт албан болон албан бус хэлбэрээр, хот болон хөдөө орон нутагт, цахим болон танхимаар гэх зэрэг нийгэм соёлын орчин нөхцөлийн харилцан адилгүй байдлаар үргэлжилсээр байна.

Монгол Улсад дээд боловсролтой хөөмийч бэлтгэж эхлээд даруй 20 жилийн нүүрийг үзжээ. Энэ хугацаанд багшийн заах арга барил, сургалтын орчин, суралцагчийн бүтээлч сэтгэлгээ гээд сургалтын олон талын хэлбэрүүд өөрчлөгдөн сайжирсаар байна. Харин сургалтын үйл явцад Б.Одсүрэнгийн гэх заах аргын хэв загвар бүрэлдэн тогтсон эсэхийг ажиглалт, ярилцлагын судалгааны үр дүнгээр дараах байдлаар нэгтгэн дүгнэж болмоор байна. Үүнд:

- Б.Одсүрэнг хөөмийн сургалтын мастер буюу нэрт сурган хүмүүжүүлэгч болоход түүний ой санамж дахь бага насны дурсамж, өсөж торнисон орчин, түүнээс анзааран таньсан амьдралын арга ухаан, идэвхтэй туршилт гээд энэ бүхний нэгдлээр үүсэж бий болсон мэдлэг нь орчин цагийн хөөмийн танхимын сургалтын дэгийг бүрдүүлэхэд нөлөөлсөн чухал хүчин зүйл болсон гэж үзэж болно;
- Б.Одсүрэнгийн хөөмий заах аргын үйл явцын тогтолцоонд хүний сэтгэхүй, физиологийн онцлогийг шинжих, уламжлалт арга ухаанаар хөгжүүлэх, дадлага туршилтаар идэвхтэй ажиглалт хийх, түүнд суурилож авьяас, ур чадварыг хөгжүүлэх гэсэн процессууд хамаарч байна. Энэ үйл явцын тогтолцоо нь суралцагчид мэдлэг, дадлага, чадварыг бий болгож байна хэмээн харж байна;
- Б.Одсүрэнгийн хөөмий заах арга барилын онцлогийг боловсролын онолч

Д.Колбын “Туршилтаар танин мэдэх онол”-д суурилан сургалтын явцыг ажиглалт, туршлагаас үүдэх мэдлэг, туршилт гэсэн үндсэн процессын хүрээнд зураглаж болмоор. Энэхүү заах арга барилын загварыг “туршлагад суурилсан загвар” хэмээн нэрийдэх саналтай.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Жаонни Кюртэт. 2018. “Монгол дахь хөөмийн өвлүүлэлт.” *Чингис хаан судлал*.

Боть XXII: 141-146.

Одсүрэн, Б. 2009. “Хөөмэйлэх арга барил.” Магистрын судалгааны ажил. Соёл урлагийн их сургууль.

Хийморьтой (Haimuritai). 2024. “Хөөмийлөх ур чадвар” сургалтны хөтөлбөрийн туршилт судалгаа.” Боловсрол судлалын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон диссертац. Монгол Улсын Боловсролын их сургууль.

Хэрлэн, Л. 2010. “Монгол хөөмэйн утга холбогдол хийгээд дуун ухааны харилцан хамаарал.” Урлаг судлалын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон диссертац. Монгол Улсын их сургууль.

Цэдэн-Иш, А. 2009. *Хөгжим*. Улаанбаатар.

Энэбиш, Ж. 2007. *Уран сайхны шүүмж буюу онгодыг өдөөгч “халгай”*.

Улаанбаатар: Арвай принт хэвлэлийн газар.

Гадаад хэлээр:

David A.Kolb. 1981. About Experience Based Learning Systems (EBLS). <https://digitalcommons.unomaha.edu/>

Eeva Kaisa Nyry-Beihammer. 2010. “Master-apprentice relation in music teaching From a secret garden to a transparent modelling.” *Nordic Research in Music Education*. Yearbook Vol.12 (2010): 161-178.

Klaus Nielsen, Steinar Kval. 1997. Current issues of apprenticeship. *Nordisk Pedagogik*. Vol.17: 160-169.

Gholson, Sylvia A. 1998. Proximal positioning: A strategy of practice in violin pedagogy. *Journal of Research in Music Education* 32(2): 113–122.

Van Manen, M. 1994. Pedagogy, virtue, and narrative identity in teaching. *Curriculum Inquiry* 4(2), 135-170.

Ярилцлага:

Баатарын Одсүрэнтэй хийсэн ярилцлага. СУИС-ийн “Үндэсний язгуур урлаг”-ийн

танхим, 120 тоот, 2024.03.15.

Баатарын Одсүрэнтэй хийсэн ярилцлага. СУИС-ийн “Үндэсний язгуур урлаг”-ийн танхим, 120 тоот, 2024.03.22.

Баатарын Одсүрэнтэй хийсэн ярилцлага. СУИС-ийн “Үндэсний язгуур урлаг”-ийн танхим, 120 тоот, 2024.03.29.

Баатарын Одсүрэнтэй хийсэн ярилцлага. СУИС-ийн “Үндэсний язгуур урлаг”-ийн танхим, 120 тоот, 2024.04.05.

Баатарын Одсүрэнтэй хийсэн ярилцлага. СУИС-ийн “Үндэсний язгуур урлаг”-ийн танхим, 120 тоот, 2024.04.26.